



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2018 оны 11 сарын 20 өдөр

Дугаар 122/УАГ-ГАГ/2017/12-ГА-01

Номгон

Г Төлбөр барагдуулах тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Үндэсний аудитын газрын орон нутаг дахь төрийн аудитын газруудтай хамтран ажиллах төлөвлөгөөний дагуу Баянхонгор аймагт байршилтай ЖДҮДС-аас хөнгөлөлттэй зээл авсан зээлдэгчдийн төслийн зээлийн хэрэгжилтийг шалгахад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Баянхонгор аймгийн харьяат “Хөх хуруу” ХХК нь Хасбанкны Баянхонгор аймаг дахь салбараас 2014 оны 09 дүгээр сарын 18-ны өдөр жилийн 7 хувийн хүүтэй, 60 сарын хугацаатай, 216,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг хувийн цэцэрлэг байгуулах зориулалттай авчээ. 2018 оны 11 дүгээр сарын 14-ны өдөр хөнгөлөлттэй зээлийн зарцуулалтыг шалгахад хувийн цэцэрлэг байгуулахаар байр худалдан авсан гэх боловч үйл ажиллагаа явуулаагүй байна.

Энэ нь Хасбанкны Баянхонгор аймаг дахь салбартай байгуулсан 1210011880 дугаартай зээлийн гэрээний 3.4.1-т заасан “Зээлийн хөрөнгийг банкны бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр энэ гэрээнд зааснаас бусад зориулалтаар ашиглахгүй байх”, зээлийн гэрээний тусгай нөхцлийн 2.7.3-т заасан “Зээлдэгч нь зээлийн хөрөнгийг Үндсэн гэрээнд заасан зориулалтаар ашиглаагүй тохиолдолд зээлийг нэн даруй буцаан төлүүлэх эсхүл зээлийн хүүний хэмжээнд өөрчлөлт оруулж, тухайн үед Банкны нийтэд зарласан бизнесийн зээлийн дээд хүүд шилжүүлнэ...”, Аж үйлдвэрийн сайдын 2016 оны 48 тоот тушаалаар баталсан “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих зорилгоор хөнгөлөлттэй зээл олгох журам”-ын 5.6-т заасан “Хяналт, шинжилгээ, үнэлгээний явцад илэрсэн зөрчил, дутагдлыг ажлын хэсэг газар дээр нь шийдвэрлэн ажиллах ба зээлийг зориулалт бусаар ашигласан, хууль, журам зөрчиж олгосон зэрэг нь хяналт, шалгалтын байгууллага, яамны хамтарсан ажлын хэсгийн дүгнэлтээр тогтоогдсон тохиолдолд тухайн өдрөөс эхлэн уг зээлийг дамжуулан олгосон банкны арилжааны зээл рүү шилжүүлэн жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх санд банк эх үүсвэрээс бүрэн дүнгээр буцаан төвлөрүүлнэ...” гэснийг зөрчсөн байна.

2518125

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх ...”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1.7 дахь “...төлбөрийн акт тавих үндэслэлтэй бусад нөхцөл байдал гаргасан” зөрчилд төрийн аудитын байгууллага төлбөрийн акт тогтооно гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Зээлдэгч “Хөх хуруу” ХХК нь ЖДҮДС-ийн эх үүсвэрээс олгосон хөнгөлөлттэй зээлийг зориулалт бусаар зарцуулсан тул 2018 оны 11 дүгээр сарын 12-ны өдрөөрх хөнгөлөлттэй зээлийн үлдэгдэл 49,489,572 / Дөчин есөн сая дөрвөн зуун наян есөн мянга таван зуун далан хоёр/ төгрөгийг бизнесийн зээлд шилжүүлж, зээлийн эх үүсвэрийг Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих санд шилжүүлэх
2. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, холбогдох баримтыг 2018 оны 11 дүгээр сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянхонгор аймгийн Хасбанкны захирал Г.Олонбаярт хариуцуулав.

#### АКТЫГ

<b>ТОГТООСОН<sup>1</sup>:</b>	
АХЛАХ АУДИТОР 	Б.ДОЛЖМАА
АУДИТОР 	Б.НАРАНГЭРЭЛ
<b>ХЯНАСАН:</b>	
АУДИТЫН МЕНЕЖЕР 	Д.ЦЭЦЭГМАА

<b>ЗӨВШӨӨРСӨН:</b>	
ХАСБАНКНЫ ЗАХИРАЛ 	Г.ОЛОНБАЯР
ХУВИЙН БАНКИР 	Т.БАЯНЖАРГАЛ
“ХӨХ ХУРУУ” ХХК-ИЙН ЗАХИРАЛ 	Б.МӨРДОРЖ



1. Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2018 оны 11 сарын 20 өдөр

Дугаар 123/ҮАГ-ГАГ/2017/12-ГА-01 Номгон

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Үндэсний аудитын газрын орон нутаг дахь төрийн аудитын газруудтай хамтран ажиллах төлөвлөгөөний дагуу Баянхонгор аймагт байршилтай ЖДҮДС-аас хөнгөлөлттэй зээл авсан зээлдэгчдийн төслийн зээлийн хэрэгжилтийг шалгахад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Баянхонгор аймгийн Баянхонгор сумын Номгон 1 дүгээр багийн иргэн П.Энхбат нь Хасбанкны Баянхонгор аймаг дахь салбараас 2014 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр жилийн 7 хувийн хүүтэй, 60 сарын хугацаатай, 30,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг үндсэн хөрөнгийн зориулалттай авчээ. Зээлийн хөрөнгөөр гахайн алаг мах болон хагас боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэж, байнгын 4 ажлын байр бий болгохоор төсөлд заасан байхад үйл ажиллагаа явуулж байгаад 2018 оны 04 дүгээр сараас үйл ажиллагааг зогсоосон, зээлийг хугацаанд төлөөгүй хугацаа хэтрүүлсэн байна.

Энэ нь Хасбанкны Баянхонгор аймаг дахь салбартай байгуулсан 1640002198 тоот зээлийн гэрээний тусгай нөхцлийн 2.7.3-т заасан “Зээлдэгч нь зээлийн хөрөнгийг Үндсэн гэрээнд заасан зориулалтаар ашиглаагүй тохиолдолд зээлийг нэн даруй буцаан төлүүлэх эсхүл зээлийн хүүний хэмжээнд өөрчлөлт оруулж, тухайн үед Банкны нийтэд зарласан бизнесийн зээлийн дээд хүүд шилжүүлнэ...”, Аж үйлдвэрийн сайдын 2016 оны 48 тоот тушаалаар баталсан “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих зорилгоор хөнгөлөлттэй зээл олгох журам”-ын 5.6-т заасан “Хяналт, шинжилгээ, үнэлгээний явцад илэрсэн зөрчил, дутагдлыг ажлын хэсэг газар дээр нь шийдвэрлэн ажиллах ба зээлийг зориулалт бусаар ашигласан, хууль, журам зөрчиж олгосон зэрэг нь хяналт, шалгалтын байгууллага, яамны хамтарсан ажлын хэсгийн дүгнэлтээр тогтоогдсон тохиолдолд тухайн өдрөөс эхлэн уг зээлийг дамжуулан олгосон банкны арилжааны зээл рүү шилжүүлэн жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх санд банк эх үүсвэрээс бүрэн дүнгээр буцаан төвлөрүүлнэ...” гэснийг зөрчсөн байна.



Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх ...”, Монгол

2518127

Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1.7 дахь “...төлбөрийн акт тавих үндэслэлтэй бусад нөхцөл байдал гаргасан” зөрчилд төрийн аудитын байгууллага төлбөрийн акт тогтооно гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Зээлдэгч П.Энхбат нь ЖДҮДС-ийн эх үүсвэрээс олгосон хөнгөлөлттэй зээлийг зориулалт бусаар зарцуулсан тул 2018 оны 11 дүгээр сарын 12-ны өдрөөрх хөнгөлөлттэй зээлийн үлдэгдэл 7,500,000 /Долоон сая таван зуун мянган/ төгрөгийг бизнесийн зээлд шилжүүлж, эх үүсвэрийг Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих санд шилжүүлэх
2. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, холбогдох баримтыг 2018 оны 11 дүгээр сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянхонгор аймгийн Хасбанкны захирал Г.Олонбаярт хариуцуулав.

### АКТЫГ

<b>ТОГТООСОН<sup>1</sup>:</b>	<b>ЗӨВШӨӨРСӨН:</b>
	
АХЛАХ АУДИТОР <i>[Signature]</i> Б.ДОЛЖМАА	ХАСБАНКНЫ ЗАХИРАЛ
АУДИТОР <i>[Signature]</i> Б.НАРАНГЭРЭЛ	Г.ОЛОНБАЯР
<b>ХЯНАСАН:</b>	ЗЭЭЛИЙН МЭРГЭЖИЛТЭН
АУДИТЫН МЕНЕЖЕР <i>[Signature]</i> Д.ЦЭЦЭГМАА	Ү.СОЁЛМАА
	БАЯНХОНГОР СУМЫН 1-Р БАГИЙН
	ИРГЭН <i>[Signature]</i> П.ЭНХБАТ

1. Акт, албан шаардлагын биелэлт хангаагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу харууцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.